



“МОН-ИТ БУЛИГААР” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2021 оны 03 сарын 10 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай

Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1, 59.4 дахь заалт, 60 дугаар зүйлийн 60.1, 60.2 дахь заалт, 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь заалт, 65-р зүйлийн 65.3, 65.4 дэхь заалт, 71 дүгээр зүйлийн 71.1, 71.3 дахь заалт, 76 дугаар зүйлийн 76.1.8, 76.1.18 дахь хэсэг, Санхүүгийн Зохицуулах Хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ны өдрийн 377 дугаар тоот тогтоолоор батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”, компанийн 2021 оны 3 дугаар сарын 10-ний өдрийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

Нэг. “Мон-Ит Булигаар” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал (цаашид “Хурал” гэх)-ыг 2021 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн 14:00 цагт Монгол улс, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 2-р хороо, “Мон-Ит Булигаар” ХК-ийн байранд хуралдуулсугай.

Хоёр. “Мон-Ит Булигаар” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлыг хэлэлцүүлсүгэй.

- 2.1. “Мон-Ит Булигаар” ХК-ийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах;
- 2.2. “Мон-Ит Булигаар” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг шинээр сонгох;

Гурав. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлах тухай мэдэгдлийг 2021 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн дотор Монголын хөрөнгийн бирж болон Санхүүгийн зохицуулах хороонд тус тус хүргүүлсүгэй.

Дөрөв. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрхтэй Хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2021 оны 03 дугаар сарын 31-ний өдрөөр тогтоосугай.

Тав. Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах тухай зарыг 2021 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн дотор Монголын хөрөнгийн биржийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд зарлан, зарыг олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр дамжуулан

мэдээлсүгэй. Энэхүү хурлын зарыг анх зар хүргэсэн өдрөөс хойш 15 хоногийн дараа буюу 2021 оны 03 дугаар сарын 30-ний өдөр дахин зарлан хувьцаа эзэмшигчдэд мэдээлсүгэй.

Зургаа. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудал, гаргах шийдвэрийн төсөл, түүнтэй холбоотой баримт бичгийг 2021 оны 03 дугаар сарын 20-ний өдрийн дотор үнэт цаасны брокер дилерийн компаниудад хүргүүлсүгэй.

Долоо. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар Б.Анхболдыг мөн хурал зохион байгуулах комиссын даргаар А.Энхмэнд, гишүүдэд Ц.Мөнхлхагва, Н.Тэмүүжин нарыг сонгосугай.

Найм. Дараах нэр бүхий хүмүүсийг хурлын тооллогын комиссын бүрэлдэхүүнээр томилсугай.

Хурлын тооллогын комиссын дарга – Б.Баянжаргал

Хурлын тооллогын комиссын гишүүд – М.Төрхүү, Д.Ариунбилэг

Ес. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын саналын хуудасны загварыг нэгдүгээр хавсралтаар баталсугай.

Арав. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг нийтэд хүргэх зарын загварыг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

Арван нэг. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын материал, баримт бичгийг гуравдугаар хавсралтаар баталсугай. Энэхүү хурлын материалтай ажлын өдрийн 09:00-18:00 цагийн хооронд хувьцаа эзэмшигчид танилцах боломжийг бүрдүүлэхийг Гүйцэтгэх захирал Б.Анхболд-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА:



А.ЭНХМЭНД